

## ХУТУГ УУЛЫН РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛУУД (Урьдчилсан судалгаа)

Ц.БАТТУЛГА<sup>1</sup>, Б.АЗЗАЯА<sup>2</sup>

*МУИС, ГХСС, Түрэг судлалын тэнхим*

<sup>1</sup>*e-mail: centreturkicamongol@yahoo.com*

<sup>2</sup>*e-mail: centreturkicamongol@yahoo.com*

*Түлхүүр үгс: Монголын руни бичиг, Хутуг уулын бичээс*

**ТОВЧ АГУУЛГА:** Хутуг уулын бичээсийг анх 1975 онд Е.Трыарски, Ж.Хамилтон нар, 1976 онд М.Шинэхүү гуай уншиж судалсан байна. Тэд Хутуг уулын хоёр мөрөөс бүтэх нэгэн бичээсийн тухай өгүүлсэн байдаг.

Бидний хийсэн судалгааны үр дүнд Хутуг уулнаа хоёр мөрөөс бүтэх цор ганц бичээс бус нийтдээ таван хэсэг бичээс буйг олж тогтоосон билээ. Эл өгүүлэлд Хутуг уулаас шинээр олдсон руни бичээсийг уншиж тайлсан судалгаагаа нийтлүүлж байна.

Монгол нутагт эртний түрэг, уйгур улсын үед холбогдох түүх археологийн болон үсэг бичгийн дурсгал нэн арвин байдаг билээ. Сүүлийн жилүүдэд руни бичгийн тэдгээр дурсгалуудыг дахин нягтлах, шинэ бичгийн дурсгал илрүүлэх, аман мэдээг нягтлах, сурвалжлах ажлыг МУИС-ийн Түрэг Судлалын Төв (тэнхим)-ийн хамт олон идэвхтэй зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд Түрэг судлалын төвөөс 2007 оны 10-р сарын 5-6-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын нутаг Таацын голын баруун эрэгт орших Хутуг уулын бичээсийг нягтлан судалсан юм.

Энэхүү хээрийн судалгааны багт Түрэг судлалын III, IV ангийн оюутнууд оролцсон болно.

Анх Таацын голын саваар хайгуул хийж явсан Германы геологичид илрүүлсэн гэх бөгөөд тэд Баянхонгор аймгийн нутгаас олсон хэмээн мэдээлжээ (Laur, 1972: 1-38)<sup>1</sup>.

Е.Трыарски, Ж.Хамилтон нар анх уншиж судалсан (Tryjarski, Hamilton, 1975) тухай мэдээ байдаг бөгөөд эдгээр эрдэмтэд геологичдын нийтлүүлсэн эхэд тулгуурлан уншиж тайлсан нь мэдээж хэрэг юм. Бид эдгээр судлаачдын уншлага судалгааг хараахан олж үзэж чадаагүй болно.

Дээрх судалгааны ажлын мөрөөр 1973 оны зун Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан шинжилгээний ангийн “Бичээс, хадны зураг судлах” багийнхан энэхүү бичгийн дурсгалыг дахин үзэж судалжээ<sup>2</sup>. Уг хээрийн шинжилгээний

<sup>1</sup> М.Шинэхүү гуайн бүтээлээс дам эшлэв.

<sup>2</sup> Эл хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Шинэхүү хоёр оюутны хамт, Зөвлөлтийн ШУА-ийн Дорно дахины

ангийн бүрэлдэхүүнд ажилласан түрэг судлаач М.Шинэхүү руни бичгийн эл дурсгалыг уншиж судлан нийтлүүлсэн ажээ.

Бидний судалгааны үр дүнд шинээр дөрвөн хэсэг, тус бүр нэг мөр бичээс илрүүлсэн болно. Цаг хугацааны давчууд ахин дахин нягтлах боломж хараахан бага байсан тул нарийвчилсан хайгуулыг бүрэн, хангалттай хэмжээнд хийж амжаагүй билээ. Тиймээс ч урьдчилсан судалгаагаа толилуулахын далимд, Хутуг уулын бичээс, хадны зураг дурсгалыг дахин нягтлах зайлшгүй шаардлагатайг тэмдэглэе.

Судалгааг харьцуулан үзэхэд тустай хэмээн үзэж М.Шинэхүү абугайн уншлага орчуулгыг бүрэн эхээр нь толилуулж байна.

### ***М.Шинэхүү гуайн судалгаа***

Үсэгчлэн уншвал:

1. Qrakrütᠠrkᠠn
2. Tjigᠠnᠴur

Үгчлэн уншвал:

1. Qara kār᠋kū (kōrkū?) tāᠠᠨᠵᠢkän
2. Ata Jigin anᠴur

Сонгодог монгол бичгийн хэлнээ орчуулбал:

1. Qar-a kerükü ᠠᠨᠵᠢ-yin
2. eᠴige Yigin-anᠴur

Орчин цагийн утга зохиолын хэлээр найруулбал:

1. Хар хэрэх тэнгэрийн
2. Эцэг Ийгин-анчур

хэмээгээд тэрбээр орос хэлнээ “Кара (черного) кэрку (злого, препятствующего) Тэнгэри (неба) отец Ййгин-Анчур” хэмээн орчуулсан ажээ (Шинэхүү, 1976: 36-42).

### ***Бидний судалгаа***

#### **Нэгдүгээр бичээс**

Нэгдүгээр бичээс нь Хутуг уулын оройн дөрвөн зүг, найман зовхист салбарласан 24 овооноос 20 орчим алхам доор, уулын зүүн урагш харсан талд, хар хүрэн өнгийн үхэр чулуунаа буй. Хүрмэн чулууны толигор гадаргуу дээр нэг, хоёрдугаар мөрийн эхлэлийг бараг залгуулан хурц өнцөг үүсгэн сийлжээ. Бичээс бүхий хаднаа 8 янгир, тэдний нэгийг агнахаар нум сум тавьж буй хүн, цахилж яваа янзагын зураг цохисон байна. Эл зураг хийгээд Хутуг уулын хадны зургууд он цагийн хувьд хүрлийн үед холбогдох нь илэрхий байна. Холцруулан цохих аргаар бичсэн эл бичээсийн бичлэгийн хэлбэр тиг сайн, тодорхойгоос гадна элэрч долорсон зүйлгүй тул алхмын холоос ч уншигдахуйц юм.

---

судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.А.Новгородова, жолооч Б.Борис нар оролцсон ажээ.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ïkrhQwkrkARQ.1

RvWigjT.2

Үсгийн галиг:

1. Q R a k r ü t η r k n
2. T y g n nĕ W R

Үгийн галиг:

1. qara kārku tāṅrikān
2. at yigin anĉur

Орчуулга:

1. Хар Кэркү тэнгэрхэн
2. нэр Ийгин Анчур

### Тайлбар

М.Шинэхүү гуайн судалгаанаас үзэхэд tāṅrikān гэх үгийн “kän” нөхцлийг харьяалахын тийн ялгалын нөхцөл мэтээр ухаарсан байна. Үнэндээ энэ нь тийн ялгалын нөхцөл бус харин руни бичгийн дурсгалуудад, нэн ялангуяа уйгурын үеийн бичгийн дурсгалд олонтоо тохиолддог өргөмж нэр, цол юм. Нэгдүгээр мөрийн бичээсийг ийнхүү уншсандаа тулгуурлан утга холбож, хоёрдугаар мөрийн эхний үгийг “эцэг” гэж тайлсантай санал нийлэхгүй байна.

Эл бичээсийн нэгдүгээр мөрнөө Хутуг уулын өргөмж нэрийг, хоёрдугаар мөрнөө уг бичээсийг бичигч “өөрөө бичсэнээ тодруулан” “нэр Ийгин Анчур” хэмээжээ.

Хутуг уулыг тухайн үед Ийгин Анчур хэмээх язгууртан буюу тэдний овог аймаг, эсвээс түүний захиргаанд байгсад тахиж шүтдэг байсан бололтой.

Бидний санахад, Хар хэрэх тэнгэрхэн гэдэг нь бөөгийн тэнгэртэй холбоотой бус харин уул овооны тахилга, шүтээнтэй холбоотой болов уу хэмээн үзэж байна.

Учир нь нэгд, эл уулыг эрт цагт тахиж байсны ул мөр болох “хутуг буюу өлзийт” хэмээх нэртэй байна. Хоёрт, kārku гэх үгийн язгуур нь kerik бөгөөд их том, өргөн уудам гэсэн утгатай билээ. Ийн үзвээс Хар Их Тэнгэрхэн гэсэн утгатай, Хутуг уулын өргөмж нэр байхыг үгүйсгэх аргагүй. Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт буй Арханангийн бичээснээ “qaya tāṅrikān qutluу boluṅ- хад тэнгэрхэн өлзийтэй болог” (Баттулга, 2005: 115-121) хэмээн хад, уулаа тэнгэрхэн хэмээн өргөмжилж өлзий оршин, хишиг буянаа хайрлахыг бэлгэдсэн нь бий. Өөрөөр хэлбэл, “тэнгэрхэн” хэмээх өргөмж цолыг зөвхөн язгууртан, ихэст ч бус тахилгат уул, хайрханд ч бас соёрхож өргөмжилдөг байсан бололтой хэмээн үзэж болох юм.

М.Шинэхүү абугайн “Энэхүү бичээсэнд гарч байгаа qara kārku tāṅri хэмээхийг бөө мөргөлийн муу зүгийн хараал зүхлийн 55 хар тэнгэр (qar-a tngri), сайн зүгийн ээрсэн хүслийг хангагч 44 цагаан тэнгэр (ĉayan tngri) гэгчийн qar-a tngri-тэй холбон үзэж болох мэт санагдана. Яагаад гэвэл энэ бичээсэнд гарч байгаа

тэнгэрийн өнгө нь бөө мөргөлийн муу зүгийн хараал зүхлийн тэнгэрийн өнгөтэй тохирч байгаагаас гадна тэнгэрийн нэр *kärkü* нь сонгодог монгол бичгийн хэлний *kerükü* (хэрэх) гэдэг үгтэй утга дүйж догшин хэрцгий тэнгэр гэсэн санааг илэрхийлж байна. Тухайлбал, *qara kerkü* (хэрэх) гэдэг үг нь хэрж торлох, хэсэж тэнэх гэсэн утгатайгаас гадна бусдын эсрэг *qiluyiqu* (хялайх), *küriçikü* (хүрцэх) гэсэн утга санаа бас агуулна. Хялайх, хүрцэх гэдэг нь *januqu* (занах), *jükekü* (зүхэх) гэсэн санаа бөгөөд *kerükü*, *torulaqu* (торлох) хэмээх нь *saγad totqar* (саад тотгор) гэсэн бас нэгэн утга илэрхийлж байна. Мөн *kerüjü joγsuqu* (хэрж зогсох) гэхүл урдуур өмнүүр нь хөндөлсөн “саад хийх” санаа юм. Эдгээр утга санаа нь нэг үгээр хэлбэл хараал зүхлийн л илрэл болой. Одоо ч гэсэн сайн сэтгэл, сайхан үйлийг *ᠰaγan sanaγ-a* (цагаан санаа), муу сэтгэл, бузар үйлийг *qar-a sanaγ-a* (хар санаа) хэмээн өгүүлсээр буй нь бөө мөргөлийн *qar-a tngri* (хар тэнгэр), *ᠰaγan tngri* (цагаан тэнгэр) гэгчтэй холбоотой болов уу гэж санана” (Шинэхүү, 1976 : 40) гэж тэмдэглэсэн байна.

Үүнээс үзэхэд, *kärkü* гэх үгийн язгуурыг сонгодог монгол бичгийн хэлний *kerükü* (хэрэх) хэмээх үгтэй утга дүйлгэж “догшин, хэрцгий” гэж ойлгосноос улбаалан бичээсийг бөө мөргөлтэй холбон ташаа ухаарахад хүргэжээ.

#### **Хутуг уулаас шинээр илрүүлсэн бичээсүүд**

Бид Хутуг уулнаа буй нэг бичээсийг үзэж судлах зорилготой очсон бөгөөд хайгуул судалгаа хийсний үр дүнд тус бүр нэг мөр дөрвөн бичээс шинээр илрүүллээ.

Шинээр олдсон бичээсийг байрлалын хувьд уулын оройгоос уруудуулан дугаарласан болно.

#### **Хутуг уулын хоёрдугаар бичээс**

Хутуг уулын оройд, овооны чанх хойд талд газраас дөнгөж цухуйсан цайвар бор чулуунаа нэг мөр бичээсийг холцруулан цохих аргаар төдий л гүн бус бичжээ. Бичээсийн төгсгөлийн “г” үсгийн зөвхөн нуруу нь үлдсэн байсан бөгөөд нөгөө хэсэг нь хагарсан хэлтэрхий дээр байсныг тэмдэглэе.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

госQQu

Үсгийн галиг:

ük ük ᠰ W R

Үгийн галиг:

ükük ᠰur

Орчуулга:

Үкүк чур

Үкүк нэртэй чур цолтой нэгэн энд бичиж үлдээсэн бололтой. Эл бичээсийг дагалдуулан ямар нэгэн тамга тэмдэг сийлээгүй байна.

### Гуравдугаар бичээс

Хутуг уулын баруун ард, уулын бүсэлхий орчимд нэг мөр руни бичээс, бичээсийн доод хэсэгт могой болон үл мэдэгдэх хэдэн амьтны зураг цохижээ.

Бичээс бүхий чулууны урт 71 см, бичээсийн нийт урт 32 см, үсгийн өндөр 7,5 см, үсэг хоорондын зай 1 см.

Эл бичээснээ [ $>SuSdXv$ ]? гэсэн зургаан тэмдэгт буй боловч уншихад эргэлзээтэй юм.



Зураг 1. Хутуг уулын 1-р бичээс



Зураг 2. Хутуг уулын 2-р бичээс



Зураг 3. Хутуг уулын 3-р бичээс



Зураг 4. Хутуг уулын 4-р бичээс



Зураг 5. Хутуг уулын 5-р бичээс

### Дөрөвдүгээр бичээс

Хутуг уулын баруун хойно, гуравдугаар бичээсээс доош 100 орчим метрийн зайтай гурван үсгээс бүтсэн нэг мөр бичээсийг таван талтай, газраас дээш 104 см өндөр шовгор бор чулууны 16 см өргөнтэй, зүүн өмнө талд бичжээ. Уг хадны баруун хоёр талд нь хадны зураг буй.

## ХУТУГ УУЛЫН РУНИ БИЧГИЙН ДУРСГАЛУУД

Үсгийн өндөр 5 см, үсэг хоорондын зай 1 см, бичээсийн нийт урт 8,5 см.

Бичээсийн эхийн сийрүүлгэ: ...RJI

Үсгийн галиг: Ү у г ...

Үгийн галиг: ау уяг ....

Орчуулга: сар газар ....

Хэдийгээр “сар газар” хэмээн уншиж болох ч бичээс сийлсэн хад хэлтэрч унасан тул бүрэн утга илэрхийлэхгүй байна.

### Тавдугаар бичээс

Хутуг уулын баруун урд энгэрт, хавтгай хүрэн бор чулуун дээр нэг мөр хялгасан бичээс мэт зүйл харагдаж байвч бичээс гэхэд төдий л баттай бус болохыг тэмдэглэе.

Бичээс бүхий чулууны урт 164 см, өргөн 101 см, бичээсийн нийт урт 35 см, үсгийн өндөр 5,5-6 см болно.

Эл бичээснээ [L(W)uBulw]? гэсэн зургаан тэмдэгт төдий л баттай бус харагдаж байна.

Бид Хутуг уулын руни бичээсүүдийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор урьдчилсан судалгаагаар танилцууллаа. Цаашид эдгээр бичээсийг дахин нягтлан үзэх зайлшгүй шаардлагатайг тэмдэглэе.

### НОМЗҮЙ

*Баттулга Ц.*, 2005. Монголын руни бичгийн бага дурсгал. Тэргүүн дэвтэр. УБ.

*Шинэхүү М.*, 1976. Хутуг уулын эртний түрэг бичээс. ШУА-ийн Мэдээ. №4. тал 36-42.

*Laur D.*, 1972. Archäologische Beobachtungen aus dem Bajan-Chongor-Aimak der Mongolischen Volksrepublik. Felszeichnungen und Inschriften, -“Ethnographisch-Archäologische Zeitschrift” Veb Deutscher verlag Der Wissenschaften 1972.H.1, S.1-38.

*Tryjarski E, Hamilton J.H.*, 1975. L’inscription turque runiforme de Khutug-Ula. -Journal Asiatique. Paris

### SUMMARY

Ts.Battulga

### RUNIC INSCRIPTIONS IN THE KHUTUG UUL

In this article author suggests deciphering of the five runic inscriptions discovered on the several rock surfaces of the Mt.Khutug near river Taats, Baruun Bayan Ulaan soum, Uburkhangay province, Mongolia.

Inscriptions are analyzed by the style of the runic characters and contents of the descriptions as well. The inscriptions are dated to the period of Uighurs domination among nomads in Mongolia.

#### *The 1<sup>st</sup> inscription*

##### **Origin of the inscription:**

## ïkrhQwkrkARQ.1

### RvWigjT.2

**Transliteration:**

1. Q R a k r ü t η r k n
2. T y g n nč W R

**Transcription:**

1. qara kärkü täηrikän
2. at yigin ančur

**Translation:**

1. Black *Kerku tengriken*
2. name *Yigin Anchur*

#### *The 2<sup>nd</sup> inscription*

**Origin of the inscription:**

rocQQu

**Transliteration:**

ük ük č W R

**Transcription:**

ükük čur

**Translation:**

Ukuk chur (*Ukuk-name, chur-title*)

#### *The 3<sup>rd</sup> inscription*

It is important to note that there are six characters (>SuSdXv)? correct reading of which presents some difficulty. Therefore the exact reconstruction of the text and correct reading of its contents are under doubt.

#### *The 4<sup>th</sup> inscription*

**Origin of the inscription:**

...RJI

**Transliteration:**

Y y r ...

**Transcription:**

ay yär ....

**Translation:**

moon land ....

We have some possibility to read the character “ay” as ‘moon’ and “yär” as ‘land’ respectively. But due to eroded surface in some part of the rock, it is hard to catch exact meaning of this text.

#### *The 5<sup>th</sup> inscription*

It should be noted that on the surface of a brownish rock some traces like a runic text appeared, but it was difficult to prove.

The size of the rock, which has an inscription, is 164 cm long and 101 cm wide. The inscription itself is 35 cm long and height of the characters is approximately 5.5-6 cm. There are six characters (L(W)uBulw) appearance of which is not clear. Therefore, a correct reading of this text presents some difficulty.

The author point on further elaborated scientific investigation of the newly discovered inscriptions